



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/150

Номгон

Эзэмшил газрын зөрчлийг
арилгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2010 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 351 дүгээр захирамжийн хавсралтийн 1 дэхь хэсэгт заасан иргэн Б.Цэндэд холбогдох нийтийн орон сууцны зориулалттай 400м² газар дээр илүү эзэмшиж буй 97 м² газрыг газар эзэмшигч иргэн Б.Цэнд, С.Ганбат нарын хүсэлтийн харгалзан нэмж эзэмшүүлэн, хавсралтаар баталж өөрчилсүгэй.

2.Илүү эзэмшиж буй 97 м² газрын үнийг төлүүлэн зөрчлийг арилгасугай.

3.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.


4.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Б.Цэнд, С.Ганбат нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210379

Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын
01-ний өдрийн А/150 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Хамтран эзэмшигч	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Б.Цэнд	BT37070101	С.Ганбат /ВЭ63112014/	040700232 3-001	Нийтийн орон сууц	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Рашаантын гудамж-3, 314 тоот	400 м2	97 м2	497 м2

-----oO-----